

АЖЛЫН ДААЛГАВАР

#	
Огноо	2024-04-10
Хаалтын огноо	
Ажлын нэр	Хүүхдийг ивээх санд ERP систем нэвтрүүлэх ажлын удирдамж

Хүүхдийг Ивээх Сан (ХИС) нь хүүхдийн төлөөх үйлсээрээ дэлхийд тэргүүлэгчдийн нэг, шашин, улс төрөөс ангид, олон улсын, бие даасан төрийн бус байгууллага юм. ХИС нь дэлхийн 120 улсад хүмүүнлэгийн болон хөгжлийн чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Монгол Улсад 1994 оноос ажиллаж байна. Монгол Улс дахь ХИС нь Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн засаглал, Боловсрол, Хүүхдийн ядуурлыг бууруулах, Эрүүл мэнд, Хүмүүнлэгийн тусламжийн үндсэн чиглэлүүдийн дагуу ажилладаг. 2022 оны байдлаар 58,580 хүн үүнээс 41,310 хүүхэд ХИС-аас хэрэгжүүлсэн төслийн үр шимийг хүртээд байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хуудаснаас авна уу. (<https://savethechildren.mn/>)

ЗОРИЛГО

ХИС нь төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааны зохион байгуулалтыг цахимжуулж, нэгдсэн системээр удирдах боломжийг бий болгох зорилготой.

ЗОРИЛТ

- ХИС-гийн дотоод үйл ажиллагааг цахимжуулах шийдэл боловсруулах /Odoо ERP системийн модуль сонгох, нэмэлт хөгжүүлэлтийн төлөвлөгөө гаргах/;
- Модулиас бүрдсэн, үүлэн технологид суурилсан ERP систем хөгжүүлэх, тохируулах;
- ХИС-гийн ажлын урсгалыг автоматжуулсан, хялбар харагдац, ажиллагаа бүхий ERP систем нэвтрүүлэх;
- ERP систем нь санхүү, төслийн удирдлага, агуулах, худалдан авалтын удирдлага, Хүний нөөц, цалингийн удирдлага гэсэн модулиас бүрдэх;
- Байршил, цаг хугацаа үл харгалзан аюулгүй, хялбар аргаар нэвтэрч ажиллах ERP систем нэвтрүүлэх;
- ERP системийн хэрэглэгчийн гарын авлага, системийн техникийн гарын авлагаар хангах;
- ERP системийн гол хэрэглэгчийг сургах.

ERP СИСТЕМИЙН ШААРДЛАГА

Модуль

ERP систем нь дараах үндсэн модулиас бүрдэх ба эдгээр модультай хамт ажилладаг туслах модультай байж болно:

1. Санхүү: Нягтлан бодох бүртгэл (Accounting), Хөрөнгө (Assets), Зардал (Expenses), Нэхэмжлэл (Invoicing);
2. Төслийн удирдлага: Үүрэг даалгавар (Tasks), Төсөл (Project), Төлөвлөлт (Planning);
3. Худалдан авалтын удирдлага: Худалдан авалтын сонгон шалгаруулалт (Purchase), Бараа материалын бүртгэл (Inventory), Засвар үйлчилгээ (Maintenance);
4. Хүний нөөц, цалингийн удирдлага: Ажилтан (Employees), Сонгон шалгаруулалт (Recruitment), Чөлөө (Time Off), Томилолт (Business Trip).

Техникийн шаардлага

1. Системийн програмчлал олон улсын стандартын дагуу бичигдсэн байх бөгөөд интерфэйсийн хувьд олон улсын usability, accessibility стандартыг хангасан байна.
2. Систем нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын хууль эрх зүйтэй нийцсэн байна.
3. Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдсөн, Сангийн Яамны тусгай зөвшөөрөл бүхий, байнга шинэчлэл сайжруулалт хийгддэг программ хангамж байна.
4. Систем нь нэгдсэн архитектураар зохион байгуулагдсан байна.
5. Үүлэн технологид суурилсан веб хөтөчөөр хандах боломжтой бөгөөд SSL хамгаалалттай байна.
6. Өгөгдлийн сан нууцлалтай, халдашгүй, хүртээмжтэй байх бөгөөд UNICODE дэмждэг байна.
7. Бүх модулиуд уялдаатай бөгөөд холбоотой мэдээллийг хуваалцаж ажиллах боломжтой байна.
8. Системийг нээлттэй буюу ОУ стандартад туссан аргачлалын дагуу хөгжүүлж, нэвтрүүлсэн байна.
9. Программ хангамж нь орчин үеийн технологи дээр суурилсан, өөрчлөлт, сайжруулалтыг богино хугацаанд хийх техник болон технологийн шийдэлтэй байна.
10. Системийн шинэчлэл сайжруулалтын тусгай зориулалтын файл уншуулж шинэчлэл хийгддэг байх
11. Өгөгдлийн сан өдөр бүр 12:00-04:00 цагийн хооронд автоматаар backup хийгддэг байх. Мөн нэмэлт хард диск, usb диск дээр эрх бүхий ажилтан нөөцөлж авах боломжтой байна.
12. MS Excel болон XML файлаас өгөгдөл импортлох болон MS Excel, XML, PDF форматаар өгөгдлийг экспортлоно.
13. Мэдээллийг импортлох XML, MS excel template загвартай байна.
14. Хэрэглэгчийн төрөл, зөвшөөрөгдсөн эрхийн хүрээнд систем нь ялгаатай интерфэйстэй байх ба хэрэглэгчийн хандалтын түүх бичигдэж байна.
15. Байгууллагын дотоод үйл ажиллагааг автоматжуулна. Тухайлбал, худалдан авалтын захиалга, зөвшөөрөл, электрон хэлбэрээр хүсэлт гаргах, зөвшөөрөл олгох, батлах, эдгээртэй холбоотой үйлдлийг сануулах, мэдээллэх гэх мэт.
16. Систем нь гар утасны аппликейшнтай байх эсвэл гар утасны хөтөчөөр нэвтэрч ашиглах боломжтой буюу responsive байна.
17. Систем нь MS Office файл, скайнердсан баримт /PDF/ болон зураг /JPG, PNG/ зэргийг хадгалах, дуудах боломжтой байх (нэхэмжлэл, барааны зураг гэх мэт).
18. Программ хангамж нь тодорхой хугацааны лицензгүй байх эсвэл лицензийг 3-аас 5 жилээр сунгах боломжтой байна.
19. Тайлан шинжилгээг график болон бүдүүвч зургаар гаргадаг байна.
20. Системийн эх кодыг захиалагчид хүлээлгэн өгсөн байх ба шаардлагатай сургалт, гарын авлагаар хангана.
21. Системийг захиалагчийн зөвшөөрсөн серверт байршуулж ажиллуулна.
22. Ажилтны и-мэйл хаяг нь системийн хэрэглэгчийн нэр байх ба нууц үгээр эсвэл бусад дүйцэхүйц аргаар системд нэвтрэх боломжтой байна.
23. 3 удаа амжилтгүй нэвтрэх оролдлого бүртгэгдсэн бол хэрэглэгчийн эрхийг хязгаарлах ба CAPTCHA хамгаалалт ашиглана.
24. Тайлан мэдээ, зөвшөөрлыг эрх бүхий хэрэглэгч чеклэх, эсвэл товч дарах зэргээр баталгаажуулалт хий боломжтой байна.

Хүлээгдэж буй үр дүн, хугацаа

- Шаардлагад нийцсэн ERP систем нэвтрүүлсэн байна.

- ERP системийн гарын авлага, техникийн дэмжлэг үзүүлсэн байна.
- Системийн эх код, нэвтрэх эрхийг хүлээлгэн өгсөн байна.
- Системийн тусгай эрх бүхий ажилтныг сургаж, хэрэглэгчийн гарын авлагаар хангасан байна.

Зөвлөх хувь хүнд тавих мэргэжлийн шаардлага

- Программ хангамж, компьютерийн ухааны чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх,
- Мэдээллийн технологийн салбарт 3-аас дээш жил ажилласан ажлын туршлагатай байх,
- Судалгаа шинжилгээ хийх, баримт бичиг боловсруулах, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх,
- Мэргэжлийнхээ чиглэлийн агуулгыг Англи хэл дээр ойлгох чадвартай байх,
- Багаар хамтран ажиллах чадвартай, харилцааны соёлтой байх,
- Ажлын ачаалал даах чадвартай, шаардлагатай тохиолдолд илүү цагаар ажиллах боломжтой байх,
- Python, Postgre SQL, Javascript, JQuery, JSON, XML зэрэг програмчлалын хэлний мэдлэгтэй байх,
- Ubuntu 22.04 server OS, SSL, SMTP, Cloud Service, API-ын мэдлэгтэй,
- Odoо ERP дээр хөгжүүлэлт хийж байсан бол давуу тал болно.

Ирүүлэх материал

Шаардлага хангасан хувь хүн хүсэлтээ илэрхийлсэн дараах баримт бичгийг ирүүлнэ.

1. Иргэний үнэмлэхийн хуулбар;
2. Дээрх ажлын шаардлагуудыг хэрхэн хангаж буйгаа тайлбарласан захидал буюу Cover Letter
3. Өөрийн ажил, мэргэжлийн түүхийг харуулсан намтар буюу Resume
4. Боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
5. Гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалт (мэдээлэл, жишээ болохуйц системийн линкүүд).

Хугацаа

Сонирхсон этгээд мэдүүлгээ 2024 оны 05-р сарын 06-ны өдрийн 17:00 цагаас өмнө mongolia.jobs@savethechildren.org цахим шуудангаар .pdf өргөтгөлтэй файл хэлбэрээр ирүүлнэ үү.